НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүннү хотын захирагчийн ажлын албаны
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/499/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: Цахим хаяг: gantugss@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Цолмон<br>Утас: Цахим хаяг: Tsolmonba@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна у

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 406
танай ________ -ны № ________ -т

ХҮННҮ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Ц.БУМАНБУЯН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,548.9.0 сая төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Хүннү хотын төлөвлөлтийн үзэл баримтлалын баримт бичиг боловсруулах олон улсын уралдаант шалгаруулалт зохион байгуулахаар Нийслэлийн засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/329 дугаартай захирамжаар 2,000.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

1428052011

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

**Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 17 зорилтын хүрээнд 103 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 97.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

Document1

## ХОЁР.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### _1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/Төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,488,770.00** | **51,311,924.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2,488,770.00 | 51,311,924.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 2,488,770.00 | 51,311,924.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 392,500.00 | 12,479,508.00 |
| 35420 | Аж ахуйн материал | - | 11,248,996.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,096,270.00 | 27,583,420.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,786,777.84** | **515,497,400.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 10,786,777.84 | 515,497,400.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 10,786,777.84 | 512,497,400.39 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 26,131,200.00 | 370,520,700.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (21,959,363.54) | (54,935,800.05) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,309,000.00 | 210,289,700.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,694,058.62) | (13,377,199.56) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | - | 3,000,000.00 |
| 39301 | Программ хангамж | - | 3,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **13,275,547.84** | **566,809,324.39** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **13,275,547.84** | **566,809,324.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 13,275,547.84 | 566,809,324.39 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 13,275,547.84 | 566,809,324.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | - | 13,275,547.84 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 13,275,547.84 | 553,533,776.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **13,275,547.84** | **566,809,324.39** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЯЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **98,104,998.85** | **3,535,075,946.99** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,771,400.90** | **560,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,771,400.90 | 560,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 13,771,400.90 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,771,400.90 | - |
| 120009 | Бусад орлого | - | 560,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **84,333,597.95** | **3,534,515,946.99** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 2,037,001,159.43 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,000,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 36,441,159.43 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 84,333,597.95 | 1,498,074,787.56 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,333,597.95 | 1,498,074,787.56 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **84,829,451.01** | **2,981,542,170.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **84,829,451.01** | **2,981,542,170.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 84,829,451.01 | 1,678,014,609.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 71,029,926.41 | 637,396,782.06 |
| 210101 | Үндсэн цалин | 70,624,926.41 | 584,451,309.37 |
| 210102 | Нэмэгдэл | 405,000.00 | 21,682,472.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 31,263,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,405,991.54 | 71,674,486.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,758,134.65 | 51,080,763.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 710,299.27 | 6,363,124.09 |
| 210203 | ҮЙМНЭ-ний даатгал | 63,775.00 | 1,206,776.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 173,775.00 | 1,028,116.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 700,007.62 | 11,995,706.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 236,425,293.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 42,146,823.45 |
| 210302 | Түлш, халаалт | - | 10,144,740.97 |
| 210304 | Байрны түрээс | - | 184,133,729.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,722,199.00 | 112,304,320.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 870,580.00 | 17,125,422.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,417,000.00 | 53,439,430.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 401,500.00 | 3,145,964.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,033,119.00 | 38,593,504.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 53,119,500.00 |
| 210602 | Тавилга | - | 5,141,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 47,978,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 10,455,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 198,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | 10,257,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 293,265,052.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 272,773,762.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 20,491,290.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 671,334.06 | 263,373,274.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 220,713,697.54 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 671,334.06 | 42,659,577.45 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 1,303,527,561.43 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 1,300,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,300,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 3,527,561.43 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,527,561.43 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,275,547.84** | **553,533,776.55** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **13,275,547.84** | **553,533,776.55** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЯЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **84,333,597.95** | **3,535,075,946.99** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **560,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **-** | **560,000.00** |
| 120009 | Бусад орлого | - | 560,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **84,333,597.95** | **3,534,515,946.99** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 2,037,001,159.43 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,000,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 36,441,159.43 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 84,333,597.95 | 1,498,047,787.56 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,333,597.95 | 1,498,047,787.56 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **84,333,597.95** | **2,987,705,746.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **84,333,597.95** | **2,987,705,746.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **84,333,597.95** | **1,684,178,185.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 71,029,926.41 | 637,396,782.06 |
| 210101 | Үндсэн цалин | 70,624,926.41 | 584,451,309.37 |
| 210102 | Нэмэгдэл | 405,000.00 | 21,682,472.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 31,263,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,405,991.54 | 71,674,486.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,037,543.74 | 51,080,763.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 710,299.27 | 6,363,124.09 |
| 210203 | ҮЙМНЭ-ний даатгал | 118,775.00 | 1,206,776.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 118,775.00 | 1,028,116.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,420,598.53 | 11,995,706.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 236,425,293.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 42,146,823.45 |
| 210302 | Түлш, халаалт | - | 10,144,740.97 |
| 210304 | Байрны түрээс | - | 184,133,729.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,897,680.00 | 131,737,134.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,179,180.00 | 29,212,430.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,417,000.00 | 53,439,430.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 401,500.00 | 3,145,964.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 900,000.00 | 45,939,310.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 53,119,500.00 |
| 210602 | Тавилга | - | 5,141,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 47,978,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 10,455,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 198,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | 10,257,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 304,200,052.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 283,708,762.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 20,491,290.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 239,169,037.54 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 239,169,037.54 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **1,303,527,561.43** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 1,300,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,300,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 3,527,561.43 |
| 213403 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 560,000.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал | | 2,967,561.43 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮИЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **547,370,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **547,370,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **547,370,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 547,370,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 547,370,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮИЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(547,370,200.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮИЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | 13,275,547.84 | 13,275,547.84 |
| 8 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 13,275,547.84 | 13,275,547.84 |
| 11 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | 13,275,547.84 | 13,275,547.84 |
| 16 | Тайлант үеийн үр дүн | - | - | 553,533,776.55 | 553,533,776.55 |
| 17 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 566,809,324.39 | 566,809,324.39 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **2,908,551,700.00** | **1,498,074,787.56** | **1,410,476,912.44** | **52%** |
| 12 | Татварын бус орлого | 2,908,551,700.00 | 1,498,074,787.56 | 1,410,476,912.44 | **52%** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 560,000.00 | - 560,000.00 | **0%** |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | - | 560,000.00 | - 560,000.00 | **0%** |
| 122 | Тусламжийн орлого | 2,908,551,700.00 | 1,497,514,787.56 | 1,411,036,912.44 | **51%** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 2,908,551,700.00 | 1,497,514,787.56 | 1,411,036,912.44 | **51%** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,908,551,700.00** | **1,498,074,787.56** | **1,410,476,912.44** | **52%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,908,551,700.00** | **1,498,074,787.56** | **1,410,476,912.44** | **52%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,843,663,700.00** | **1,498,074,787.56** | **1,345,588,912.44** | **53%** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,634,274,500.00 | 637,396,782.06 | 996,877,717.94 | **39%** |
| 210101 | Үндсэн цалин | 979,788,900.00 | 584,451,309.37 | 395,337,590.63 | **60%** |
| 210102 | Нэмэгдэл | 391,915,600.00 | 21,682,472.69 | 370,233,127.31 | **6%** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 262,570,000.00 | 31,263,000.00 | 231,307,000.00 | **12%** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **204,284,300.00** | **71,674,486.14** | **132,609,813.86** | **35%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 138,913,300.00 | 51,080,763.05 | 87,832,536.95 | **37%** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,342,700.00 | 6,363,124.09 | 9,979,575.91 | **39%** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,171,400.00 | 1,206,776.51 | 6,964,623.49 | **15%** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,171,400.00 | 1,028,116.06 | 7,143,283.94 | 13% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,685,500.00 | 11,995,706.43 | 20,689,793.57 | 37% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 265,940,000.00 | 236,425,293.82 | 29,514,706.18 | 89% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,600,000.00 | 42,146,823.45 | - 35,546,823.45 | 639% |
| 210302 | Түлш, халаалт | 60,600,000.00 | 10,144,740.97 | 50,455,259.03 | 17% |
| 210304 | Байрны түрээс | 198,740,000.00 | 184,133,729.40 | 14,606,270.60 | 93% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **109,059,900.00** | **65,848,593.00** | **43,211,307.00** | 60% |
| 210401 | Бичиг хэрэг | 19,310,000.00 | 14,936,860.00 | 4,373,140.00 | 77% |
| 210402 | 3Тээвэр, шатахуун | 64,547,000.00 | 32,039,430.00 | 32,507,570.00 | 50% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,767,200.00 | 3,145,964.00 | 9,621,236.00 | 25% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,000.00 | - | 330,000.00 | 0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,105,700.00 | 15,726,339.00 | - 3,620,639.00 | 130% |
| 2105 | Нормативт зардал | 9,850,000.00 | - | 9,850,000.00 | 0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,850,000.00 | - | 9,850,000.00 | 0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **471,261,000.00** | **445,281,700.00** | **25,979,300.00** | 94% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 254,739,000.00 | 244,689,500.00 | 10,049,500.00 | 96% |
| 210602 | Тавилга | 168,522,000.00 | 152,613,700.00 | 15,908,300.00 | 91% |
| 210604 | Урсгал засвар | 48,000,000.00 | 47,978,500.00 | 21,500.00 | 100% |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,040,000.00 | 10,455,900.00 | 5,584,100.00 | 65% |
| 210702 | Дотоод албан томилолт | 198,000.00 | 198,000.00 | - | 100% |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 15,842,000.00 | 10,257,900.00 | 5,584,100.00 | 65% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **99,554,000.00** | **15,081,290.00** | **84,472,710.00** | 15% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,000,000.00 | 4,540,000.00 | 3,460,000.00 | 57% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | - | 5,000,000.00 | 0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 86,554,000.00 | 10,541,290.00 | 76,012,710.00 | 12% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,400,000.00 | 15,910,742.54 | 17,489,257.46 | 48% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,400,000.00 | 15,910,742.54 | 17,489,257.46 | 48% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **64,888,000.00** | **-** | 64,888,000.00 | 0% |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 64,888,000.00 | - | 64,888,000.00 | **0%** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 64,888,000.00 | - | 64,888,000.00 | **0%** |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | - | - | - | **0%** |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | - | - | **0%** |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | - | - | **0%** |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | **2%** |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | **100%** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | **100%** |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 28.00 | - | 28.00 | **0%** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | - | 1.00 | **0%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 27.00 | - | 27.00 | 0% |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 28.00 | - | 28.00 | 0% |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1.0 | - | 1.0 | 0% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,036,441,159.43 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,036,441,159.43 |
| 122 | Тусламжийн орлого | 2,036,441,159.43 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 2,036,441,159.43 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,036,441,159.43 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000,000.00 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,441,159.43 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,033,473,598.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,033,473,598.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 733,473,598.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 67,948,541.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,275,570.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 32,272,971.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 99,700,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 99,700,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 292,118,762.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 279,168,762.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,950,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 273,706,295.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 273,706,295.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,300,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,300,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,300,000,000.00 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 2,967,561.43 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - 2,967,561.43 |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - 2,967,561.43 |

## ГУРАВ.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,480,599.0 мянган төгрөгийн 11 зөрчил[1] илэрснээс 6,550.6 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 2,295,073.1 мянган төгрөгийн 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 41,345.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

## ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант оны үр дүнг дутуу илрэрхийлсэн | 1 | 553,533.8 | 1 | 553,533.8 | | | 1 | 553,533.8 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд худалдаж авсан хөрөнгийн зардлыг дутуу тайлагнасан. | 1 | 547,370.2 | 1 | 547,370.2 | | | 1 | 547,370.2 | | | | |
| **Нийт** | **2** | **1,100,904.0** | | | | | **2** | 1,100,904.0 | | | | |

Хүннү хотын захирагчийн ажлын албаны
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн мөнгөөр нэрийн хуудас хэвлүүлж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. | 1 | 700.0 | 1 | 700.0 | | | | |
| Дотоодын хэрэгцээнд тушаал шийдвэргүй, үдэслэлгүй кофе цай бэлтгэж төсвийг үр ашиггүй захиран зарцуулсан байна. | 1 | 4,762.7 | 1 | 4,762.7 | | | | |
| Дотоод албан томилолтоор ажилласан ажлын тайлан томилолтын хуудас байхгүй томилолтын тооцоог бодож хаагаагүй байна | 1 | 1,087.9 | 1 | 1,087.9 | | | | |
| Олон улсын уралдаанд шалгарсан оролцогчдийн шагналын гүйлгээний шилжүүлсэн баримт нотлогдохгүй байна | 1 | 1,180,000.0 | | | 1 | 1,180,000.0 | | |
| Сонгон шалгаруулалтгүй зах зээлийн үнээс өндөр үнээр оффисын байр түрээслэж төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна. | 1 | 168,598.3 | | | 1 | 168,598.3 | | |
| Үндсэн хөрөнгө,бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүй байна | 1 | 566,809.3 | | | 1 | 566,809.3 | | |
| Анхан шатны баримтгүй, хөрөнгө зарцуулсан ажлын тайлангүй, нотлох байримтгүй ажил гүйгээг бүртгэлд тусгасан байна. | 1 | 362,603.0 | | | 1 | 362,603.0 | | |
| Ашиглагдахгүй байранд түрээсийн зардал төлсөн байна | 1 | 17,062.5 | | | 1 | 17,062.5 | | |
| Программ хангамж үйлчилгээг ажлын гүйцэтгэлээр гэрээг дүгнээгүй, ажлын тайлангүй зардал гаргасан байна. | 1 | 6,750.0 | | | | | 1 | 6,750.0 |
| Олон улсын уралдааны шүүгчдийн онгоцний тийзний зардлын үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгон үйлчлүүлээгүй байна. | 1 | 17,017.8 | | | | | 1 | 17,017.8 |
| Нэмэлт санхүүжилтийн данснаас зориулалт бусаар үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна | 1 | 155,208.5 | | | | | 1 | 155,208.5 |
| **Дүн** | **11** | **2,480,600.0** | **3** | **6,550.6** | **5** | **2,295,073.1** | **3** | **178,976.3** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 471/ А0260461 Улаанбаатар хот

НТАГ-2026/499/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

**Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:**

**Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй оффист 17,062,500.00 (*арван долоон сая жаран хоёр мянга таван зуу*)-н төгрөгийн түрээсийн зардал төлсөн байна.**

**Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*Хариуцлагатай байх*" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.**

**Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:**

1. **Үйл ажиллагаа явуулаагүй оффиссын байранд түрээсийн зардал төлсөн зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;**
2. **Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нарт даалгав.**

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| **ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР** | **Г.НАНДИНЖАРГАЛ** |
| **АУДИТЫН МЕНЕЖЕР** | **С.ГАНТӨГС** |
| **АХЛАХ АУДИТОР** | **Б.ЦОЛМОН** |

---

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090887

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 472/А0260461 Улаанбаатар хот

НТАГ-2026/499/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд 566,809,300.00 (*таван зуун жаран зургаан мянга найман зуун есөн мянга гурван зуу*)-н төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж тооцоог бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "*Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна*", 12.2-д "*Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ*", 12.2.1-д "*жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө*", 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д "*комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх*"санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2."*хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгө,бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүй байгаа зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС
АХЛАХ АУДИТОР Б.ЦОЛМОН

---

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091076

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 473/А02600161 Улаанбаатар хот

НТАГ-2026/499/НА-СТА-ТШЗ.

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд хөрөнгө зарцуулсан ажлын тайлангүй нотлох баримтгүй 362,603,000.00 (*гурван зуун жаран хоёр сая зургаан зуун гурван мянга*)-н төгрөгийн ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйлийн 13.7-д "*анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*" санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан зөрчлийг зогсоож, зөрчил гаргасан Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нарт хариуцлага тооцож биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүннү хотын М.Батбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС
АХЛАХ АУДИТОР Б.ЦОЛМОН

---

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091078

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 494/A0261 461 | Улаанбаатар хот

НТАГ-2026/499/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сонгон шалгаруулалтгүй зах зээлийн үнээс өндөр үнээр 168,598,300.00 (*зуун жаран найман сая таван зуун ерэн найман мянга гурван зуу*)-н төгрөгийн оффисын байр түрээслэж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7.3-д "*Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална*", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*Хариуцлагатай байх*" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*",санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 44.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сонгон шалгаруулалтгүй зах зээлийн үнээс өндөр үнээр оффисын байр түрээслэж төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Г.НАНДИНЖАРГАЛ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | С.ГАНТӨГС |
| АХЛАХ АУДИТОР | Б.ЦОЛМОН |

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090847

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 18 өдөр Дугаар 475/А/0260461 Улаанбаатар хот

НТАГ-2026/499/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүннү хотын төлөвлөлийн үзэл баримтлалын баримт бичиг боловсруулах олон улсын уралдаанд шалгарсан оролцогчдын шагналд шилжүүлсэн 1,080,000,000.00 (Нэг тэр бум наян сая ) төгрөгийн ажил гүйлгээ нь анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримт хангалтгүй байна.Энэ нь

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4. *"хуулиар зөвшөөрөөгүй бусад"* Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Уралдаант тэмцээний шагнал шилжүүлсэн 1,080,000,000.00 (Нэг тэр бум наян сая ) төгрөгийн зарцуулалтад Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дотоод аудитын албыг хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС
АХЛАХ АУДИТОР Б.ЦОЛМОН

---

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1428091196

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 18 өдөр  Дугаар 203/А2026081  Улаанбаатар хот

НТАГ-2026/499/НА СТА-ТШЗ

## Төлбөрийн акт тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоодын хэрэгцээнд тушаал шийдвэргүй 4,762,700.00 (*дөрвөн сая долоон зуун жаран хоёр мянга долоон зуу*)-н төгрөгийн кофе, цай бэлтгэж төсвийг үр ашиггүй захиран зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*Хариуцлагатай байх*" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "*Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн*" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дотоодын хэрэгцээнд тушаал шийдвэргүй 4,762,700.00 (дөрвөн сая долоон зуун жаран хоёр мянга долоон зуу)-н төгрөгийн кофе цай бэлтгэж төсвийг үр ашиггүй захиран зарцуулсан төлбөрийг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ-ын хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 29-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС
АХЛАХ АУДИТОР Б.ЦОЛМОН

---

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110276

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 204/А02602НС1 Улаанбаатар хот

НТАГ - 2026/499/НА - СТА - ТШ3

## Төлбөрийн акт тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод албан томилолтоор ажилласан 1,087,900,00 (*нэг сая наян долоон мянга есөн зуун*)-н төгрөгийн ажлын тайлан, томилолтын хуудас байхгүй томилолтын тооцоог бодож хаагаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн *13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно,* санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "*Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн*" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дотоод албан томилолтоор ажилласан ажлын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан 1,087,900,00 (нэг сая наян долоон мянга есөн зуун)-н мянган төгрөгийг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ-ын хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 29-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС
АХЛАХ АУДИТОР Б.ЦОЛМОН

---
[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110274

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 205 /А02260461 Улаанбаатар хот
НТАГ-2026/499/НА-СТА-ТШЗ

Төлбөрийн акт тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүннү хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 700,000.00 (*долоон зуун мянга*)-н төгрөгөөр нэрийн хуудас хэвлүүлж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Төсвийн тухай хуулийн 5.1.5-д *"хариуцлагатай байх"*, 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*,6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "*Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн*" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсвийн мөнгөөр нэрийн хуудас хэвлүүлсэн 700,000.00 (*долоон зуу*)-н мянган төгрөгийг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ-ын хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 29-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүннү хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Буманбуян, нягтлан бодогч Г.Мөнхцолмон нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС
АХЛАХ АУДИТОР Б.ЦОЛМОН

---

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110272